



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.11.11 - 11.15

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд түүхэн дээд ханшиндаа хүрч өсөлттэй хаагдлаа. Энэхүү өсөлт АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрийн хүрээнд хоёр улс гаалийн татварын хэмжээг бууруулахаар санал нэгдсэнтэй холбоотой.

S&P 500 индексийн сагсанд багтах эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцаа хамгийн их өсөлттэй байсан бол Exxon Mobil компанийн хувьцааны ханш буурснаас үүдэн эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа уналттай байлаа.

Холбооны нөөцийн сангаас энэ жил гурван удаа бодлогын хүүгээ бууруулсан ба эдийн засгийн байдал бодитой үр нөлөө үзүүлэх хүртэл хүүгийн төвшинг барина хэмээн мэдэгджээ. Мөн АНУ-ын үйлдвэрлэлийн салбарын удаашрал үйлчилгээний салбарт сөрөг нөлөө үзүүлж эхэлж буйг онцоллоо.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрээс хамааран АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүдийн өсөлтийг дагаж хаагдлаа.

ХБНГУ-ын эдийн засаг 3-р улиралд 0.1%-аар өсөж хямралын ирмэгт тулжээ. ХБНГУ-ын үйлдвэрлэлийн салбар нь АНУ болон БНХАУ-ын худалдааны маргаан, Brexit-ийн тодорхойгүй байдал болон авто машины үйлдвэрлэлийн салбарт гарсан тасалдлууд сөргөөр нөлөөлжээ. Мөн Европын холбооны статистикийн холбооноос Евро бүс өмнөх улиралтай харьцуулахад 0.2% өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 1.2% өссөнийг мэдэгджээ.

Их Британи улс Brexit-ийн асуудлаас үүдэн мөн хямрахад ойр байгаа бөгөөд энэ оны 3-р улиралд эдийн засаг нь 1%-аар өсжээ.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа. Энэхүү уналтын шалтгаан нь Япон улсын энэ оны 3-р улирлын эдийн засгийн өсөлт нь 0.2% байсантай холбоотой.

Өмнөх улиралд Япон улсын эдийн засгийн өсөлт 1.8% байсан ба 3-р улирлын үр дүн нь шинжээчдийн дундаж таамаг болох 0.8%-аас доогуур байлаа.

Хэдий Япон улсын дотоод эрэлтийн төвшин өссөн ч экспортын бууралтын хэмжээ эдийн засагт сөргөөр нөлөөлсөн ба ирэх улиралд нэмэгдсэн өртгийн татварыг нэмж байгаатай холбоотойгоор хэрэглээ буурах төлөвтэй байна.

БНХАУ: АНУ болон БНХАУ-ын гадаад худалдааны эхний шатны хэлэлцээрт аль аль тал ямар нэг амлалт өгөөгүй удааширч буй болон хүлээлтээс доогуур эдийн засгийн үзүүлэлтүүдээс үүдэн уналттай хаагдлаа.

Шинжээчдийн үзэж байгаагаар худалдааны маргааны эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулахаар БНХАУ-ын эрх баригчид мөнгөний бодлогыг дахин сулруулах хандлагатай байгаа юм.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

| Индекс | Улс | Хаалт | Өөрчлөлт |
|-------------|------------|-----------|----------|
| MSE TOP 20 | Монгол | 18,829.94 | 2.02% ▲ |
| Dow Jones | АНУ | 28,004.89 | 1.17% ▲ |
| S&P 500 | АНУ | 3,120.46 | 0.89% ▲ |
| Nasdaq | АНУ | 8,540.83 | 0.77% ▲ |
| S&P/TSX | Канад | 17,028.47 | 0.89% ▲ |
| FTSE 100 | Их Британи | 7,302.94 | -0.77% ▼ |
| S&P/ASX 200 | Австрали | 6,793.70 | 1.04% ▲ |
| Nikkei 225 | Япон | 23,303.32 | -0.38% ▼ |
| Hang Seng | Хонг Конг | 26,326.66 | -5.46% ▼ |

Бондын өгөөж

| Бонд | Валют | Купон | Үнэ |
|------------------------|-------|---------|--------|
| Mongol 2024 (Хуралдай) | USD | 8.750% | 113.85 |
| Mongol 2023 (Гэрэгэ) | USD | 5.625% | 103.38 |
| Mongol 2022 (Чингис) | USD | 5.125% | 102.59 |
| Mongol 2021 (Мазаалай) | USD | 10.875% | 109.96 |
| DBM' 23 (Самурай) | JPY | 1.520% | 103.45 |
| DBM' 2023 | USD | 7.250% | 105.41 |
| TDBM' 2020 | USD | 9.375% | 102.48 |
| MGMTGE' 2022 (Өүлэн) | USD | 9.750% | 97.84 |

Зах зээлийн хүү

| Хүү | Хаалт | Өөрчлөлт |
|--------------|-------|----------|
| Libor 1M | 1.733 | -0.03 ▼ |
| Libor 3M | 1.900 | 0.00 |
| Libor 6M | 1.920 | 0.00 |
| Libor 1YR | 1.960 | -0.04 ▼ |
| US 2YR Bond | 1.604 | -0.07 ▼ |
| US 3YR Bond | 1.604 | -0.10 ▼ |
| US 5YR Bond | 1.639 | -0.11 ▼ |
| US 10YR Bond | 1.826 | -0.12 ▼ |

Валютын ханш /төг/

| Валют | 2019.11.15 | Өөрчлөлт |
|-------|------------|----------|
| USD | 2,671.60 | -1.16% ▼ |
| CNY | 377.44 | -2.47% ▼ |
| EUR | 2,944.37 | -1.39% ▼ |
| RUB | 41.57 | -1.96% ▼ |
| KRW | 2.25 | -3.85% ▼ |
| JPY | 24.66 | -0.28% ▼ |
| CAD | 2,019.96 | -1.45% ▼ |

Түүхий эдийн үнэ

| Түүхий эд | Хэмжих нэгж | Хаалт | Өөрчлөлт |
|------------------|-------------|----------|----------|
| Алт /spot/ | USD/t oz. | 1,468.21 | 0.63% ▲ |
| Мөнгө /spot/ | USD/t oz. | 16.96 | 0.89% ▲ |
| Зэс | USD/lb. | 265.15 | -1.14% ▼ |
| Нүүрс | USD/MT | 71.40 | 2.07% ▲ |
| WTI газрын тос | USD/bbl. | 57.72 | 0.84% ▲ |
| Brent газрын тос | USD/bbl. | 63.30 | 1.26% ▲ |

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Үзүүлэлт | Хугацаа | Хэмжээ |
|----------------------------------|----------|--------|
| Инфляцийн түвшин | 2019. IX | 9.00% |
| Бодлогын хүү | 2019. IX | 11.00% |
| Банк хоорондын зах зээлийн хүү | 2019. IX | 11.12% |
| Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/ | 2019. IX | 11.37% |
| Хадгаламжийн дундаж хүү /валют/ | 2019. IX | 4.95% |
| Зээлийн дундаж хүү /төгрөг/ | 2019. IX | 16.91% |
| Зээлийн дундаж хүү /валют/ | 2019. IX | 10.76% |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 52 компанийн 477.1 сая төгрөгийн 3,482,955 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Бэрх-Уул” /BEU/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 690.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Улсын их дэлгүүр” /UYD/ компанийн хувьцаа 20.00%-аар буурч 1,000.0 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 317 ширхэг үнэт цаас 32.0 сая төгрөгөөр арилжаалагджээ.

11-р сарын 15-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,517.0 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,829.94 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.02%-аар өссөн байна.



Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Зах зээлийн хураангуй

| Хураангуй | Үнийн дүн /сая төг/ |
|-----------------------|---------------------|
| Арилжигдсан үнийн дүн | 509.1 |
| Зах зээлийн үнэлгээ | 2,517,039.5 |

Зах зээлийн индекс

| Индекс | Хаалт | Өөрчлөлт |
|---------------|-----------|----------|
| MSE Top 20 | 18,829.94 | 2.02% ▲ |
| MSE I индекс | 8,744.23 | 5.02% ▲ |
| MSE II индекс | 7,620.77 | -0.56% ▼ |

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

| Компани | Ширхэг | Үнийн дүн /төг/ |
|-----------------------|-----------|-----------------|
| Ард санхүүгийн нэгдэл | 63,065 | 109,039,953 |
| Ард кредит ББСБ | 1,187,146 | 95,516,293 |
| АПУ | 97,852 | 54,022,662 |
| Ремикон | 1,021,253 | 30,437,498 |
| Сүү | 124,502 | 25,208,444 |

Өсөлттэй хувьцаа

| Компани | Хаалт /төг/ | Өөрчлөлт |
|----------------------|-------------|----------|
| Бэрх-Уул | 690.00 | 15.00% ▲ |
| Фронттиер лэнд групп | 230.00 | 15.00% ▲ |
| Монноос | 1,955.00 | 15.00% ▲ |
| Их барилга | 3,448.00 | 14.97% ▲ |
| Багануур | 1,199.00 | 12.69% ▲ |

Бууралттай хувьцаа

| Компани | Хаалт /төг/ | Өөрчлөлт |
|------------------|-------------|-----------|
| Улсын их дэлгүүр | 1,000.00 | -20.00% ▼ |
| Агротехимпекс | 800.00 | -19.96% ▼ |
| Дөрвөн-Уул | 775.00 | -13.89% ▼ |
| Монгол нэхмэл | 2,100.00 | -12.50% ▼ |
| Монгол керамик | 16,500.00 | -8.54% ▼ |

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

| Компани | Арилжааны үнийн дүн /төг/ |
|---------------------|---------------------------|
| Ард Секюритиз | 409,621,787 |
| Би Ди Сек | 150,398,836 |
| Голомт Капитал | 96,782,626 |
| Бумбат-Алтай | 76,503,633 |
| Стандарт Инвестмент | 70,012,674 |

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

| Компани | Хаалт /төг/ | ЗЗҮ /сая.төг/ |
|---------------|-------------|---------------|
| АПУ | 556.30 | 592,004 |
| Таван толгой | 6,635.00 | 349,434 |
| МИК Холдинг | 12,220.00 | 253,068 |
| Говь | 263.24 | 205,357 |
| Инвескор ББСБ | 2,109.00 | 151,274 |

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

| № | Үнэт цаасны нэр | Арилжигдсан ширхэг | Үнийн дүн /төг/ | Доод /төг/ | Дээд /төг/ | 7 хоног | Хүү |
|---|------------------------------|--------------------|-----------------|------------|------------|---------|---------|
| 1 | ZGEB-BD-15/08/20-A0295-14.5 | 10 | 1,006,300 | 100,630 | 100,630 | 156 | 14.500% |
| 2 | ZGEB-BD-20/06/20-A0260-15.14 | 307 | 30,970,160 | 100,880 | 100,880 | 156 | 15.140% |

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

| № | Симбол | Компанийн нэр | 2018 оны цэвэр ашиг /сая төг/ | Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/ | Ногдол ашиг төлөлтийн харьцаа | Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/ | Шийдвэр огноо | Бүртгэлийн өдөр | Хуваарилах өдөр |
|----|--------|---|-------------------------------|---------------------------------------|-------------------------------|----------------------------------|---------------|-----------------|----------------------|
| 1 | HRM | Гермес центр ХК | 783.4 | 298.5 | 38.1% | 3.8 | 2019.01.25 | 2019.02.18 | 2019.03.18-нд олгов |
| 2 | LEND | ЛэндМН ББСБ | 2,560.3 | 800.0 | 31.2% | 1.0 | 2019.01.30 | 2019.02.22 | 2019.03.28-нд олгов |
| 3 | MBW | Монгол Базальт ХК | 217.2 | 56.4 | 26.0% | 1.0 | 2019.02.01 | 2019.03.25 | 2019.06.14-нд олгов |
| 4 | BTG | Баянтээг ХК | 1,771.4 | 1,000.0 | 56.5% | 3,958.7 | 2019.02.11 | 2019.03.04 | 2019.06.01-с |
| 5 | SUL | Жуулчин дюти фрий ХК | 1,384.5 | 653.6 | 47.2% | 10,000.0 | 2019.02.12 | 2019.04.10 | 2019.05.31-с |
| 6 | GOV | Говь ХК | 17,764.2 | 5,304.8 | 29.9% | 6.8 | 2019.02.13 | 2019.03.28 | 2019.04.25-с |
| 7 | ADU | Хөвсгөл алтан дуулга ХК | 399.2 | 1,888.1 | 473.0% | 120.0 | 2019.02.13 | 2019.04.01 | 2019.05.01-с |
| 8 | TCK | Талх чихэр ХК | 1,975.9 | 204.7 | 10.4% | 200.0 | 2019.02.14 | 2019.04.03 | 2019.07.01-с |
| 9 | MMX | Мах импекс ХК | 778.6 | 456.1 | 58.6% | 120.0 | 2019.02.14 | 2019.04.03 | 2019.10.01-с |
| 10 | BUK | УБ-БҮК ХК | 566.4 | 131.5 | 23.2% | 1.0 | 2019.02.14 | 2019.04.05 | 2019.05.01-с |
| 11 | ТАН | Тахь-ко ХК | 799.1 | 128.5 | 16.1% | 108.0 | 2019.02.15 | 2019.04.05 | 2019.04.24-нд олгов |
| 12 | BNG | Баянгол зочид буудал ХК | 3,433.1 | 150.2 | 4.4% | 355.0 | 2019.02.16 | 2019.04.05 | 2019.09.01-с |
| 13 | MNP | Монгол шуудан ХК | 1,560.3 | 468.1 | 30.0% | 4.7 | 2019.02.18 | 2019.04.05 | 2019.05.01-с |
| 14 | HRD | Хүрд ХК | 751.1 | 74.4 | 9.9% | 550.0 | 2019.02.18 | 2019.03.04 | 2019.06.01-ний дотор |
| 15 | MNDL | Мандал даатгал ХК | 3,868.3 | 624.3 | 16.1% | 100.0 | 2019.02.18 | 2019.04.10 | 2019.05.27-нд олгов |
| 16 | GTL | Гутал ХК | 2,225.8 | 1,257.7 | 56.5% | 777.0 | 2019.02.18 | 2019.03.13 | 2019.05.06-с |
| 17 | TEX | Техник импорт ХК | 2,702.0 | 723.4 | 26.8% | 500.0 | 2019.02.18 | 2019.03.11 | 2019.04.11-с |
| 18 | APU | АПУ ХК | 57,851.7 | 48,952.4 | 84.6% | 46.0 | 2019.02.19 | 2019.04.04 | 2019.05.20-нд олгов |
| 19 | AIC | Ард даатгал ХК | 1,263.4 | 631.8 | 50.0% | 25.3 | 2019.02.19 | 2019.03.15 | 2019.06.17-нд олгов |
| 20 | GHC | Ган хийц ХК | 20.3 | 12.1 | 59.7% | 50.0 | 2019.02.19 | 2019.03.22 | 2019.10.21-нд олгов |
| 21 | HUV | Хөвсгөл геологи ХК | 107.4 | 14.4 | 13.4% | 100.0 | 2019.02.19 | 2019.04.03 | 2019.04.29-с |
| 22 | HNS | Хөвсгөл хүнс ХК | 11.3 | 2.6 | 23.4% | 10.0 | 2019.02.19 | 2019.04.03 | 2019.05.15-с |
| 23 | TAL | Талын гал ХК | 255.9 | 34.7 | 13.6% | 50.0 | 2019.02.25 | 2019.03.26 | 2019.07.19-нд олгов |
| 24 | BRC | Барилга корпораци ХК | 1,311.0 | 40.1 | 3.1% | 985.0 | 2019.02.26 | 2019.03.18 | 2019.03.18 |
| 25 | UBH | Улаанбаатар хивс ХК | 235.6 | 48.6 | 20.6% | 120.0 | 2019.02.26 | 2019.03.18 | 2019.05.31-ний дотор |
| 26 | DSS | Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК | 11.5 | 11.4 | 99.2% | 1.1 | 2019.03.01 | 2019.03.21 | 2019.07.02-с |
| 27 | ADL | Адуунчулуун ХК | 547.1 | 409.7 | 74.9% | 130.0 | 2019.03.11 | 2019.04.03 | 2019.07.26-нд олгов |
| 28 | TEE | Тээвэр дархан ХК | 22.3 | 81.7 | 365.5% | 500.0 | 2019.04.17 | 2019.03.27 | 2019.12.31-ний дотор |
| 29 | ERS | Монгол алт ХК | 6.3 | 39.9 | 631.2% | 150.0 | 2019.04.17 | 2019.03.27 | 2019.12.31-ний дотор |
| 30 | TTL | Таван толгой ХК | 52,858.1 | 44,923.4 | 85.0% | 853.0 | 2019.04.26 | 2019.04.01 | 2019.06.11-нд олгов |
| 31 | EER | Ариг гал ХК | 449.3 | 109.4 | 24.3% | 32.5 | 2019.04.26 | 2019.03.27 | 2019.09.30-ны дотор |
| 32 | HRM | Гермес центр ХК | 481.3 | 447.7 | 93.0% | 5.7 | 2019.08.15 | 2019.09.02 | 2019.09.18-нд олгов |
| 33 | SUU | Сүү ХК | 5,706.4 | 1,143.4 | 20.0% | 3.3 | 2019.09.09 | 2019.04.05 | 2019.10.24-нд олгов |

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Атар өргөө” ХК-ийн хувьцааг үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр худалдан авах санал гаргалаа

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад заасан “Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу холбогдох этгээдтэй хамтран худалдан авсан хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 57.1-д заасан үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр компанийн хувьцааг худалдан авах санал гаргана” гэж заасныг удирдлага болгон “Таван Богд Инвест” ХХК нь МХБ-ийн үнэт цаасны 2-р ангилалд бүртгэлтэй “Атар Өргөө” ХК-ийн 97,423 ширхэг энгийн хувьцаа буюу нийт энгийн хувьцааны 55.95 хувийг худалдан авах саналыг гаргалаа.

Санал гаргаж буй этгээд: “Таван Богд Инвест” ХХК /РД: 6470319, УБД: 9011811139/

Санал болгож буй үнэ: 60,200 төгрөг

Худалдан авах тоо ширхэг: 97,423 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2019 оны 11-р сарын 13

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2019 оны 12-р сарын 16-ны өдрийн 13:00 цаг

Хувьцааны худалдан авах төлбөрийг гүйцэтгэх хугацаа: 2019 оны 12-р сарын 17- ны өдөр

Санал гаргагчийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: 76,713 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 44.05%

Санал гаргагчийн харилцагч үнэт цаасны компани: “Би Ди Сек ҮЦК” ХК, 75551919-04

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион Оргил 1, Чингисийн өргөн чөлөө 6, Хаан банк цамхаг, 10-р давхар

Мэйл хаяг: invest@tavanbogd.com

Утас: 75112222.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК 3-р улирлын санхүүгийн тайлан болон хөндий алтны төслийн талаар танилцууллаа

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК (TSX:ERD | MSE:ERDN) нь 2019 оны 9-р сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын санхүү, үйл ажиллагааны тайлан болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны оролцоотой санхүүжилтийн талаар шинэ мэдээллийг танилцуулсан байна.

Тайлант хугацаанд тус компани дараах голлох үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- NI 43-101 Техникийн тайлан эерэг үзүүлэлттэй гарав.
- Баян хөндий ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2019 оны 8-р сарын 05-ны өдөр авав.
- Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ Sustainability East Asia компаниар хийлгэж байна.
- Боловсруулалтын усны нөөцийн өрөмдлөг, судалгааг хийв.

- 9-р сард Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын болон нарийвчилсан өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэв.
- 2019 оны 4-р улирлын хайгуул ба техникийн хөтөлбөрийг эхлүүлсэн.
- Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны оролцоотой 8 сая канад долларын санхүүжилтийн гэрээ байгуулсан.
- 2019 оны 9-р сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд компанийн нийт алдагдлын хэмжээ 638,379 канад долларт хүрсэн нь 2018 оны мөн үеийн үзүүлэлт болох 743,484 канад доллартай харьцуулахад буурсан үзүүлэлт боллоо.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам батламжлагдлаа

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6-р сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолоор батлагдсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалттай сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 11-р сарын 13-ны өдрийн 537 тоот тушаалаар батламжиллаа.

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлд олон шинэ үнэт цаас амжилттай гарч, хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэж, зах зээл идэвхжихийн хэрээр зах зээлийн хөрвөх чадварыг хангах, тогтвортой байдлыг бий болгох асуудал тулгамдаж байгаа бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байгаа билээ.

Энэхүү журмын дагуу олон улсын биржүүдэд түгээмэл арилжигддаг бүтээгдэхүүн манай зах зээлд цоо шинээр нэвтэрч, мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хөрөнгө оруулалтын сангууд нэгж эрхээ биржид бүртгүүлж, олон нийтэд нээлттэй арилжих ба хөрөнгө оруулагчид эрсдэлээ тараан байршуулж, багц хувьцаанд хөрөнгө оруулах замаар хөрөнгө оруулалтын оновчтой удирдлагаар хангагдах боломж бий болж байна.

Олон улсын практикаас харахад мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлснээр үнэт цаасны үнэ ханш харьцангуй бодит түвшинд, хэлбэлзэл багатайгаар тогтох, арилжааны хэмжээ нэмэгдэхээс гадна жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад эерэг нөлөө үзүүлдэг байна.

Цаашид зохицуулагч болон мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран хамтын нээлттэй сангийн нэгж эрхийг бүртгэх, арилжих зохицуулалтыг бий болгохоор ажиллаж байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

CIIE 2019: “Эрдэнэс Тавантолгой” компани Хятадын талтай хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулав

Хятадын олон улсын импортын үзэсгэлэнгийн (China International Import Expo, CIIE) Шанхай хотноо 11-р сарын 5-нд нээгдсэн бөгөөд таван өдрийн турш үргэлжлэх юм. Энэхүү үзэсгэлэн нь 2018 оноос зохион байгуулагдах болсон билээ.

Энэ жилийн үзэсгэлэнг нээж БНХАУ-ын дарга Си Жинпин үг хэлж, 2020 оны 1-р сараас Хятад улсад бизнесийн орчныг сайжруулах, зах зээлийн бүх оролцогчдын бизнес эрхлэх аюулгүй байдлыг хангах тухай төрийн шинэ бодлого хэрэгжинэ гэдгийг онцолсон байна. Тус улсын Засгийн газраас баталсан энэхүү бодлогын баримт бичигт Хятад болон гадаадын компаниудад ижил тэгш эрх, боломж олгохоор тусгасныг тодотгожээ. Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд бизнесийн орчныг таатай болгох, нэн түрүүнд дотоодын зах зээлд өндөр технологийг нэвтрүүлэхээр зорьж буй. Хятадын эдийн засгийн өсөлтийг хангах гол хүчин зүйл инновацийг хөгжүүлэх хэмээн тус улсын эрх баригчид тодорхойлж байна. “Бүс ба зам”-ын олон улсын хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, нээлттэй хэлбэрийн дэлхийн эдийн засгийг бий болгох нь Хятадын гадаадад нээлттэй байх итгэл үнэмшил, үйл ажиллагааг бүрэн харуулж байна гэдгийг тэрээр хэлсэн юм.

Хятадын олон улсын импортын 2019 оны үзэсгэлэнд дэлхийн 150 орны 3,000 гаруй компани оролцож байна. Монгол Улс үзэсгэлэнд анх удаа энэ жил оролцож байгаа бөгөөд Монголын уул уурхай, аялал жуулчлал, хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын чиглэлээр компаниуд бараа бүтээгдэхүүн, үйл ажиллагаагаа сурталчилж буй тухай МҮХАҮТ-аас мэдээлжээ. Уул уурхайн чиглэлээр Mongolian Mining Corporation буюу “Энержи Ресурс”, “Эрдэнэс Тавантолгой” компаниуд оролцсон байна. Үзэсгэлэнгийн арга хэмжээний хүрээнд, Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулах уурхайн нэгдсэн төсөлд гарын үсэг зурах ёслол болжээ. Тодруулбал, Монголын “Эрдэнэс Тавантолгой” компани Хятадын Умардын аж үйлдвэрийн групп, ӨМӨЗО-ны Бугат хотын захиргаа, Дархан Муумянган холбоот хошуу зэрэг байгууллага нэгжтэй хамтын ажиллагааны хэлэлцээр хийсэн тухай “China.com” цахим хуудаснаа мэдээлсэн байна.

Тус хэлэлцээрт Тавантолгой уурхайн жилийн хүчин чадлыг 15 сая тонн хүргэж нэмэгдүүлэх, 500 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар 3 жилийн хугацаанд коксжих нүүрсний хил дамнан тээвэрлэлт, гаалийн бүрдүүлэлт, агуулахын ложистик, Хятад дахь борлуулалт зэрэг байгууламжийг дэмжихээр тусгажээ. Мөн хоёр орны тээвэр, эдийн засаг, худалдааны холбоо, эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг ахиулан, ӨМӨЗО-ны боомтуудын эдийн засгийн хөгжлийг дэмжих асуудал багтаж буйг мэдээнд дурджээ.

“Эрдэнэс Тавантолгой” компани нь Тавантолгойн нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны 2-р сарын 27-ны өдрийн хуралдаанаар, экспортыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, дэмжих зорилтын хүрээнд холбогдох арга хэмжээ авахыг УИХ, Засгийн газарт зөвлөмж болгосон. Энэ дагуу экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанканд чиглэл өгөх тухай Эдийн засгийн байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулсан юм.

Төсөлд, экспортын өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг 2019 онд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг 2020 онд хэрэгжүүлэх, эхлэх хөрөнгө оруулалтыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2018 оны болон ирэх жилүүдийн цэвэр ашгаас санхүүжүүлэх нь зүйтэй хэмээн тусгасан. Өнгөрсөн тавдугаар сард эхэлсэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын төслийн барилгын ажилд 750 тэрбум төгрөгийн санхүүжилт хийх бөгөөд үүнийг “Монголын төмөр зам” компанийн үнэт цаасыг худалдан авах замаар шийдвэрлэхийг Засгийн газар үүрэг болгосон юм.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

Зэсийн үнэ буурах төлөвтэй байна

Лондонгийн металын бирж дээр өчигдрийн байдлаар нэг тонн зэсийн үнэ 5,854 ам.доллартайгоор хаагдсан байна. Харин Нью-Йоркийн бирж дээр зэсийн үнэ өчигдөр орон нутгийн цагаар үдээс хойших худалдааны үеэр 5,762 ам.доллар/тонн болтлоо буурчээ. Энэ нь өнгөрсөн долоо хоногтой харьцуулахад 4%-аар буурсан дүн болсныг шинжээчид онцолж байна.

Зэсийн үнэ АНУ-Хятадын худалдааны дайны асуудал нааштайгаар шийдэгдэж магадгүй гэсэн үүднээс энэ сарын эхний долоо хоногт өсөлттэй байсан бол өнгөрч буй долоо хоногт эргээд буурах шинжтэй болж ирлээ. Энэ нь АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампын мэдэгдэлтэй шууд холбоотой юм. Тэрбээр хэрэв худалдааны асуудлыг цэгцлэх эхний шатны яриа хэлэлцээр амжилтгүй болбол Хятадын бараанд хавьгүй их татвар ногдуулах болно гэдгийг мэдэгдсэн юм. Энэ нь зах зээлд худалдааны дайны асуудал тооцоолж байсан шиг нааштай биш болохыг харуулсан юм. Уг нь эхний шатны яриа хэлэлцээрт талууд Чилид болох АПЕС-ийн чуулганы үеэр гарын үсэг зурах байсан боловч хурал цуцлагдсан билээ. Одоо гэрээг үзэглэх шинэ газрыг сонгон зарлах үлдээд байгаа юм.

Үүний зэрэгцээ Хятадын Үндэсний статистикийн газар тус улсын аж үйлдвэрлэл болон бусад салбарын үзүүлэлтийг зарлалаа. Тус улсын аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлт 10-р сард 4.7%-тай байсан нь өмнөх 9-р сарын 5.8%-ийн дүнгээс буурсан байна. Хятадын Үндэсний статистикийн газар хэдийгээр 10-р сард тус улсын эдийн засгийн өсөлт тогтвортой байсан боловч өсөлт удаашрах дарамт нэмэгдсэн хэвээр байгааг анхааруулсан байна. Иймд үүнийг идэвхжүүлэхэд чиглэсэн Засгийн газрын хариу арга хэмжээ ихээхэн чухал гэдгийг тэмдэглэсэн байна.

Лондонгийн металын биржийн агуулах дахь зэсийн нөөц өчигдрийн байдлаар 221.7 мянган тоннд хүрсэн нь сүүлийн таван сар орчмын хугацаан дахь хамгийн бага дүн юм. Мөн Чилид үүсээд буй эмх замбараагүй байдлаас үүдэн зэсийн нийлүүлэлт тасалдах эрсдэл бий болоод байгаа юм. Гэхдээ эдгээр хүчин зүйл нь зэсийн үнийн өсөлтөд зөвхөн богино хугацааны эерэг нөлөө үзүүлнэ гэдгийг “Capital Economics” тэмдэглэлээ. Өөрөөр хэлбэл зэсийн үнэ өсөх эсэхэд дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал голлох нөлөө үзүүлнэ гэсэн үг.

Өнгөрсөн аравдугаар сарын сүүлээр Ройтерс-ийн 29 шинжээч ирэх онд зэсийн үнэ дунджаар 6,050 ам.доллар/тонн байна гэж үзсэн байна. Энэ нь өнгөрсөн долдугаар сард дэвшүүлж байсан таамгаас нь даруй 6%-аар бага дүн боллоо. Шинжээчид ирэх онд зэсийн үнэ өсөлтгүй байх бөгөөд харин буурах эрсдэл ихээхэн байсаар байгааг анхаарууллаа.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

БУСАД МЭДЭЭ

Монгол улсын эдийн засгийн 2019 оны 10-р сарын байдал

Мөнгө, зээл

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 10-р сарын эцэст 20.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 7.3 (0.04%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.1 (11.4%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 10-р сарын эцэст 873.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 15.9 (1.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 13.9 (1.6%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 10-р сарын эцэст 18.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 44.4 (0.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1.7 (10.6%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 10-р сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 43.9 (2.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 31.5 (1.6%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.3 пунктээр өссөн байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш 2019 оны 10-р сард 2 678.01 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар, өмнөх сараас 0.3 хувиар суларсан байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2019 оны 10-р сард 377.38 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар, өмнөх сараас 0.6 хувиар суларсан байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн рубльтай харьцах сарын дундаж ханш 2019 оны 10-р сард 41.62 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар, өмнөх сараас 1.1 хувиар суларсан байна.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний 10 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 8.8 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 8.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 545.4 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 10-р сард 1.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх сараас 222.2 (25.5%) тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 1.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 96.4 (10.3%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 78.8 хувь, хөрөнгийн зардал 18.8 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2.4 хувийг эзэлж байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 858.3 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 465.4 сая ам.доллараар буурчээ.

Урсгал данс 929.8 сая ам.долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 1.1 тэрбум ам.доллар, анхдагч орлогын данс 1.1 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2019 оны эхний 9 сард 71.5 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 8.7 (13.9%) сая ам.доллараар өссөн байна. Харин санхүүгийн дансны тэнцэл 1.4 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 295.6 (27.7%) сая ам.доллараар өсжээ.

Төлбөрийн тэнцэл 2018 оны эхний 9 сард 475.3 сая ам.долларын алдагдалтай байсан бол 2019 оны эхний 3 улиралд өмнөх оны мөн үеэс 739.5 сая ам.доллараар өсөж, 264.3 сая ам.долларын ашигтай гарчээ.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 10-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.3 хувиар буурсан бол өмнөх оны эцсээс 5.1 хувь, өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 10-р сард өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 14.0 хувь (мах, махан бүтээгдхүүний дэд бүлгийн үнэ 32.6 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.0 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 8.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 8.6 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 10.0 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.8 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 10-р сард өмнөх оны эцсээс 5.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 10.0 хувь (мах, махан бүтээгдэхүүн 27.4 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2019 оны 10-р сард өмнөх сараас 0.6 хувиар буурч, өмнөх оны эцсээс 5.4 хувь, өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өслөө.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.